

Х-1, Д-1, ХН-113, НУГАЛБАР-4

ХОТЫН ЗАХИРГААНЫ ГАЗРЫН ОРОН БАЙШИНГУУДЫГ ХӨЛСӨӨР ХЭРЭГСЭХ ЭТГЭЭДИЙН ТҮР ДАГАЖ ГҮЙЦЭТГЭХ ДҮРЭМ

НЭГ. Цалин хөлс авдаг буюу өөр зүйлийн орлоготой этгээдээс орон байшин хэрэгссэний хөлсийг энэ 12 сарын 1-нээс эхлэн сар дотор тогтоосон нь:

- Сар бүрд 70-д хүртэл цалин авдаг этгээдээс дөрвөлжин метр нэг бүрийн 20 мөнгө
- 70-иас дээш 110-д хүртэл цалинтайгаас дөрвөлжин метр нэг бүрийн 25 мөнгө
- 110-аас дээш 140-д хүртэл цалинтайгаас дөрвөлжин метр нэг бүрийн 35 мөнгө
- 140-өөс дээш 180-д хүртэл цалинтайгаас дөрвөлжин метр нэг бүрийн 45 мөнгө
- 180-аас дээш 250-д хүртэл цалинтайгаас дөрвөлжин метр нэг бүрийн 60 мөнгө
- 250-иас дээш 350-д хүртэл цалинтайгаас дөрвөлжин метр нэг бүрийн 75 мөнгө
- 350-иас дээш 400-д хүртэл цалинтайгаас дөрвөлжин метр нэг бүрийн 90 мөнгө
- 400-аас дээш цалинтайгаас дөрвөлжин метр нэг бүрийн 1-20 мөнгө

ХОЁР. Энэхүү тогтоосон хэмжээний ёсоор байшинг хөлслөн суугчдаас хөлсийг хураан авахуйд тэдний хэрэгсэж бүхий таслагуудыг хэмжээлэн уг хөлсийг ногдуулан хураах боловч хоол хийх тусгай өрөө буюу хүн суухгүй кордор хэмээх хий тасгуудаас хөлс үл хураамуй

ГУРАВ. Тус захиргааны орон байшинд энэ 12 сарын 1-ны өдөр хүртэл суусан этгээд нар нь уг хөлсийг хуучин хэвээр хураалгах бөгөөд хэрэв энэхүү дүрмээр дээр тогтоосон түрээсний хөлсийг энэ 20 дугаарын 12 сарын 1-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болгож явуулмуй.

ДӨРӨВ. Орон байшин хөлслөн суугчдаас байшингийн хөлсийг сар бүрийн шинийн нэгнээс үл хэтрүүлэн өнгөрсөн сарын хөлсийг төлөх бөгөөд хэрэв уг хугацаанаа эс төлөх этгээд үзэгдэх аваас хугацаа хэтрүүлсэн өдөр тутмын 1-ны 5 хувьд торгож уг хөлсний дээр нэмэгдүүлэн хураамуй.

ТАВ. Орон байшин хөлслөн суугчид бүрд хотын захиргааны газраас тооцооны дэвтэр олгох бөгөөд тэрхүү дэвтрийг хөлслөгчид нь хотын захиргааны газрын татвар хураагчдад үзүүлж уг байшинд суусны бүх хөлс сар бүрд хэчнээн болох ба түүнээс аль сарын хөлс хэчнээн төгрөг мөнгө төлснийг тэмдэглүүлэн бичүүлж зохих падааныг татвар хураагчдаас авбаас зохимуй.

ЗУРГАА. Хэрэв байшин хөлслөн суугчдын авч буй цалин хэрэглэл буюу ашиг орлого өөрчлөгдөх аваас цаг тухайд хотын захиргааны газар ирж мэдүүлвээс зохимуй.

ДОЛОО. Орон байшинг хөлслөн суугчдад эзлэн бүхий хашаа байшинг хог шороог зардлыг хувиас гаргаж сайтар цэвэрлэж ариун цэврийн тухай дүрмийг дагаж явах үүргийг хүлээлгэмуй.

НАЙМ. Хөлслөн суугчид нь хотын захиргааны байшингаас эрхбиш гарч одох буюу өөр газар шилжих явдал тохиолдох аваас гарах өдрөөс хоёр долоо хоногийн урд хотын захиргаанд эрэл учрыг бичгээр мэдүүлвээс зохимуй.

ЕС. Хөлслөн суугчид нь уг эзлэн суусан орон байшинд ямарваа засвар үйлдүүлэх буюу өөр зүйлийн шинэ барилга нэмэн байгуулах явдлыг хотын захиргааны зөвшөөрөлгүйгээр түүгээр үйлдэж үл болмуй.

АРАВ. Орон байшинг хөлслөн суугчдаас тэрхүү байшинг тус захиргааны зөвшөөрөлгүйгээр бусдад шилжлүүлэн түрээслэж хэрхэвч үл болмуй.

АРВАН НЭГ. Хөлслөн суугчдын гэмээр уг орон байшин нь эвдрэх муудахад хүрвээс түүнийг хөлслөгчдөөс зардлыг гаргуулж засварыг үйлдүүлмүй

УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРГААНЫ АЖ АХУЙН ХЭЛТСИЙН ЯВУУЛАН БУЙ АЖИЛ ХЭРГИЙН ТОВЧОО

1. Тус хэлтсийн орон тоо ерөнхий ангид хэлтсийн эрхэлсэн 1 инженер 1 сурагцуулагч 1 тэргүүн зэргийн монгол нягтлан бодогч 1 барилгын тасаг эрхлэгч 1 техник 1 зураач 1 газар хэмжигч 1 ажил харагч эд хогшлын тасагт эрхлэгч нэг сургагч нэг, орос нягтлан бодлогч нэг, мөнгө цуглуулагч хоёр, юм худалдан авагч хоёр эд хогшлын нярав нэг бүгд албан хаагчид болно.
2. Тус хэлтсийн дагаж хөдөлгөн буй дүрэм хэмжээнүүд
3. Тус хэлтсийн харьяа тасгууд нэрс ба орон тооны тухай нэг галын аюулыг хамгаалах газрын даргыг механик нэг, жинхэнэ жолооч гурав гурав туслах жолооч хоёр гал сэргийлэгч 14, худаг сахигч гурав
4. Тиг байгуулан газрын эрхлэгч нэг нягтлан бодох бичээч нэг, ажилчин 4 тооч 3
5. Хүүр оршуулах газар хоёр, эрхлэгч хоёр, ажилчин 4 болмуй.
6. Хотын амгалан байдлыг сахих тухай холбогдох зүйлүүд
 1. Тус хотыг бүрэн хүрэлцэхээр аль болох аргыг хэрэглэж гэрлийг тавиулах
 2. Зам гүүр зэргийг цаг тухай бүр хянаж байх ба эвдэрсэн нь шинэчлэн сэлбэн засуулж гүйцэтгэх
 3. Тус хотын доторх хог бургтийг цаг тухай бүр эргэж хянах ба үл зохилдох байдал гарах аваас цагдан сэргийлэх газартай харилцаж уг дүрэм зааварт нийлүүлэн гүйцэтгүүлэх
 4. Ард олонд хэрэглэгдэх суулгын усыг хэрхэн ариун цэврийн байдалд нийлэлцэх эсэхийг ариун цэврийг сахих их эмчийн тасагтай хавсран гүйцэтгэх
 5. Гудамжийг тэгшлэх явдлыг инженер техник нарын төсөвлөгөө авч хянан үзэж зохих аргуудыг хэрэглэн гүйцэтгүүлэх
 6. Тус хотын доторх худгуудыг шинэчлэн сэлбэн засах ба шинэ тутмаар худгийг нэмж олон болгох
 7. Тус хотын шинэ нэмэн барих олон нийтийн буюу энгийн ардуудын орон байшин ба хашаа зэргийг байгуулсны хойно алсдаа хотын байдалд тохирох эсэхийг цаг тухай бүр сайтар хянаж гүйцэтгэх
 8. Албаны буюу энгийн ардуудаас тус хотыг эргэн тойрон хамаагүйгээр газрыг түүхээр дур мэдэн малтаж нүх гаргах ба мөн зам тохиолдох нүх малтах гаргаж эдгээр зүйлүүдийг хянаж байх
 9. Тус хотын аль болох аргыг хэрэглэж энэ зун цагт цэцэрлэгийг байгуулж туршлагыг олгох
7. Мөнгө санхүү явдлыг цаг тухай бүр хянаж тайлан баланцыг гаргуулж хянаж байх
8. Тус газрын шинэ тутам байгуулсан орон суугчдыг сайнаар арьслан хамгаалж байх
9. Хуучин орон сууцууд хүний махбодод тохиромжтой болгон засуулж гүйцэтгүүлэх

Тус газрын эд болоод бэлтгэл хөрөнгө явдал аль зэргээр явж буй хянаж байх